

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал**

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан журмын дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр аймаг, орон нутагт агаарын чанарыг хэмжих суурин харуул барих ажил хэрэгжээгүй, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг ойжуулалтын арга хэмжээний хүрээнд хийхээр төлөвлөсөн ажил, модны үр, суулгацаар хэрхэн хангах, цөлжилтийг сааруулахад 2022 онд төлөвлөсөн арга хэмжээ, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос хийхээр төлөвлөсөн арга хэмжээ, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас бүрэн зогсож, Монгол Улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байгаатай холбогдуулан салбарын хүрээнд 2022 онд ямар бодлого баримтлах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал улаан буудайн борлуулалтын үнэ ханш, гурилан бүтээгдэхүүнийг экспортод гаргах асуудлын талаар, 2022 онд хүнсний ногооны тариалан эрхлэгчид, үр үйлдвэрлэгчдэд урамшуулал олгодог байх, иргэдийг халамжаас хөдөлмөрт шилжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ төлөвлөж байгаа талаар, орон нутагт сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Алтай таван богдын бүс нутагт аялал жуулчлалын чиглэлээр төлөвлөж буй ажил, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны талаар, хүн амын хүнсний аюулгүй байдлын чиглэлээр баримтлах бодлого, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг цаг

агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай хүргэдэг байхад анхаарч, энэ чиглэлээр 2022 оны төсөвт тусгасан төсөл, арга хэмжээний тухай, цөлжилтийг бууруулах чиглэлээр 2022 оны төсөвт тусгасан төсөл, арга хэмжээ хангалтгүй байгаад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал малын тоо толгой жил бүр өсөн нэмэгдэж байгааг дурдаад, махны нөөц бүрдүүлэлтэд анхаарч, экспортод гаргах талаар тооцоо судалгаа хийх, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, малчдад зөвлөмж хүргүүлж ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин шинээр байгуулагдах Ойн судалгаа, хөгжлийн газар орон нутагт ямар бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн малын гаралтай гоц халдварт цэцэг, шүлхий, мялзан, арьс товруутах зэрэг өвчин голомтлон тархаж байгаа, улсын вакцины нөөц дууссан асуудалд хариуцлага хэрхэн тооцох, импортоор хэзээ оруулж ирэх, Мал эмнэлгийн ерөнхий газар малын гаралтай өвчин, вакцинтай холбоотой асуудлаар мэдээ, мэдээллийг малчид, иргэдэд шуурхай хүргэдэггүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаад хариуцлага тооцож ажиллах талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно.


Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол гурвыг гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.6 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Г.ТЭМҮҮЛЭН**

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ  
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.**

1.Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.108-д тусгагдсан “Найрамдал төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1, 3, 4-р хороо/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 400.0 сая төгрөг, санхүүжих дүн 400.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 100.0 сая төгрөгөөр бууруулж, “Орон нутгийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж, эрүүл хүнс төсөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 100.0 сая төгрөг, санхүүжих дүн 100.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа**

2.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.5-д тусгагдсан “Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2024 он, төсөвт өртөг 94,460.1 сая төгрөг, санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, “Сумын төвийн тохижилт /Дорноговь, Замын-Үүд сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 500.0 сая, санхүүжих дүн 500.0 сая төгрөгөөр, Цэвэр усны нөөц сан /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан**

3.Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.29-д “Зоорийн байгууламж /Сэлэнгэ, Сант сум/” гэсэн төсөл, арга хэмжээг “Зоорийн байгууламж /Сэлэнгэ, Мандал сум/” гэж өөрчлөх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор**